



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 1142

Арвайхээр


Г Шинэ коронавирусын халдвараас урьдчилан
сэргийлэх, бэлэн байдлыг хангах салбар
хоорондын багуудыг томилох тухай

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах салбар хоорондын багуудыг нэгдүгээр, ажиллах чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Багуудыг мэргэжил арга зүйгээр ханганд, дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун), Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Онцгой байдлын газар (Т.Мөнхдорж), Цагдаагийн газар (О.Ганбат), Тагнуулын хэлтэс (О.Баярлхагва)-т тус тус даалгасугай.
3. Багуудын үйл ажиллагаанд шаардлагдах зардлыг тооцон, нөөц бүрдүүлж, бэлэн байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагын нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Батжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100091

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 20.00 оны 06
дугаар сарын 07-ны өдрийн 11 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх,
бэлэн байдлыг хангах салбар хоорондын
багуудын бүрэлдэхүүн

Нэг. Тохиолдлын удирдлагын тогтолцооны багийн бүрэлдэхүүн

Зохицуулагч: -Д.Шивааннурдэв аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга

Менежер: -С.Эрдэнэчулуун аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн гамшиг, яаралтай тусlamжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Э.Хүдэрчuluун -БОЭТ-ийн захирал

С.Дуламсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга

Б.Сүхбаатар -Зооноз өвчин судлалын төвийн дарга

Т.Мөнхдорж -Онцгой байдлын газрын дарга

О.Ганбат -Цагдаагийн газрын дарга

О.Баярлхагва -Тагнуулын хэлтсийн дарга

Ч.Чимэддорж -Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Өвөрхангай аймаг дахь салбарын дарга

Хоёр. Төлөвлөлт, санхүү, хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч: М.Золзаяа -аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Валя -аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын ерөнхий санхүүч

Ю.Ичинноров –аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга

Н.Намхайнямбуу -Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн,

гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч

Н.Өлзийхутаг -Цагдаагийн газрын ахлах байцаагч, цагдаагийн хошууч

Б. Шүрэнцэцэг - Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч

Д.Мөнхнасан -БОЭТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч

С.Сосорбурам - Зооноз өвчин судлалын төвийн лабораторийн их эмч

Г.Надмидсүрэн -БОЭТ-ийн тархвар судлаач эмч

Гурав. Эрсдэлийн мэдээлэл, харилцааны багийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч: -С.Дуламсүрэн аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд: -Ш.Мөнхцэцэг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын олон нийттэй харилцах ажилтан

2.

- Н.Гуамарал -аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл
мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн
- С.Пүрэвсүрэн -Онцгой байдлын газрын ангилалын сургалт,
сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан
мэргэжилтэн, ахлах дэслэгч
- Б.Туяацэцэг -Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ажил
хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад
- Д.Лхагважав -аймгийн Засаг даргын дэргэдэх мэргэжлийн
хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний
хяналтын хэлтсийн дарга
- Л.Мэнд-Амар -Зооноз ёвчин судлалын төвийн тархвар судлалын
тасгийн эрхлэгч

Аймгийн Засаг даргын 2020 оны 02
дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх,
бэлэн байдлыг хангах салбар хоорондын
багуудын ажиллах чиг үүрэг

Нэг. Тохиолдлын удирдлагын тогтолцооны багийн ажиллах чиг үүрэг:

Зохицуулагчийн үүрэг:

- Зохицуулагч нь үйл явдлын төрлөөс хамаарч баг, бүрэлдэхүүнийг томилох;
- Төлөвлөлт, санхүү, хариу арга хэмжээний гаргасан төлөвлөгөө, шаардлагатай төсвийн тооцоог аймаг, орон нутгийн удирдлага, онцгой комисст танилцуулж, бэлэн байдлыг хангах нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Багийн ахлагч нарыг үүрэгжүүлэх, удирдан чиглүүлэх, хяналт тавих;
- Менежерийг чиглүүлж, бодлогын дэмжлэг үзүүлэх;
- Байгууллага, нэгжийг идэвхжүүлэх, идэвхжлийн зэргийг өөрчлөх, цуцлах шийдвэр гаргах саналыг аймгийн Онцгой комиссын даргад хүргүүлэх
- Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах
- Салбар хоорондын багуудыг удирдан зохион байгуулах, ажлыг тайланг хэлэлцэх, шийдвэр гаргах
- Эрсдэлийн мэдээлэл, харилцаа, хэвлэлийн тоймыг хянан баталгаажуулах;

Менежерийн үүрэг:

- Багийн үүрэг, хариуцлагыг тодорхойлж, гишүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах
- Багийг хүний нөөцөөр хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- Тэргүүлэх чиглэлийг тогтоож, хариу арга хэмжээг төлөвлөж, удирдан зохион байгуулах;
- Хүний нөөц, санхүүгийн болон техникийн дэмжлэг авах талаар зохицуулагчид мэдэгдэж шийдвэрлүүлэх;
- Шуурхай хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгох, хэрэгжилтэд хяналт тавих;
- Хурлын зар түгээх, хурлын тэмдэглэл хөтлөх
- Багуудаас тайланг 7 хоног бүр авч нэгтгэн зохицуулагчид танилцуулах

Багийн гишүүдийн үүрэг:

- Хамтрагч талуудын болзошгүй нөхцөл байдлын үеийн бэлэн байдлыг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Сэжигтэй тохиолдолд өөрийн байгууллагын ажилтан, алба хаагчдыг шуурхай томилон ажиллуулах
- Өөрийн байгууллага дээр шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавих
- Зохицуулагчтай хамтран цаг үеийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах
- Бусад багийн бүрэлдэхүүнд орсон өөрийн байгууллагын албан тушаалтыг ажиллах боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх

Хоёр. Төлөвлөлт, санхүү, хариу арга хэмжээний багийн ажиллах чиг үүрэг:

- Хариу арга хэмжээний төлөвлөгөө, шаардлагатай төсвийн тооцоог салбар хоорондын байгууллагуудтай хамтран боловсруулж, бэлэн байдлыг хангахад шаардлагатай нөөцийн судалгааг тохиолдлын удирдлагын тогтолцооны багт хүргүүлэх
- Мэдээлэлд тандалт, дүн шинжилгээ, эрсдэлийн нөхцөл байдлын түргэвчилсэн үнэлгээ хийх;
- Тархалтын цар хүрээ, үйл явдлын нөхцөл, шалтгааныг тогтоох тандалт судалгаа, шинжилгээ хийх;
- Голомтыг цомхотгох, таслан зогсоох арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоох саналыг зохицуулагчид хүргүүлэх;
- Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний талаарх өдөр тутмын мэдээллийг бэлтгэж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх
- Сургамж, дүгнэлт, санал бүхий тайлан гаргаж, 7 хоног бүр тохиолдлын удирдлагын тогтолцооны багт хүргүүлэх

Гурав. Эрсдэлийн мэдээлэл, харилцааны багийн ажиллах чиг үүрэг:

- Хүн амын дундах мэдээлэл, мэдлэгийн түвшинг тогтоох судалгаа хийх, мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- Шинэ коронавирусын халдварын тархалт, цаг үеийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг цаг тухайд нь хамтрагч байгууллага, бусад багуудтай хамтран шинэчлэн боловсруулж, төрөл бүрийн сувгаар хүн амд шууд хүргэх, түгээх ажлыг зохион байгуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, мониторинг хийж, цаашдын стратегийг боловсруулах;
- Эрүүл мэндийн байгууллагуудад нээлттэй утас ажиллуулж, иргэд, олон нийтийн санаа бодлыг сонсох, тулгамдаж буй асуудлаа зөв шийдвэрлэхэд нь туслах, томуу, томуу төст өвчин, шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Хэвлэлийн бага хурал, цахим хурал, сургалт зохион байгуулж, хүн амыг нэгэн зэрэг тодорхой мэдээллээр хангах
- Иргэд, олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааны гарын авлагыг боловсруулах, хэвлүүлэх, түгээх
- Сургамж, дүгнэлт, санал бүхий тайлан гаргаж, 7 хоног бүр тохиолдлын удирдлагын тогтолцооны багт хүргүүлэх

-оОо-